

## **ХОРШООНЫ ГИШҮҮН ЭЛСҮҮЛЭХ ЖУРАМ**

Олон улсын хоршооны зарчмын дагуу хоршоонд гишүүнээр элсэх, гишүүнээс гарах нь сайн дурын бөгөөд нээлттэй асуудал юм. Гэхдээ энэ нь ямар шаардлага, зохицуулалтгүй байна гэсэн үг биш.

Хоршооны гишүүнээр элсэхийг хүсэгч нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- тухайн сумын иргэн,
- сумандаа оршин сууж, хоршооны үйл ажиллагаанд оролцох боломжтой,
- элсэлтийн татвараа төлсөн,
- хувь нийлүүлэх хөрөнгөө нийлүүлсэн,
- хоршооны дүрэм, журмыг уншиж танилцаж, хүлээн зөвшөөрсөн байх,
- хоршооны гишүүний үүргийг биелүүлж, хариуцлагыг хүлээх чадвартай байх,
- 18 ба түүнээс дээш настай байх.

Дээрх шаардлагыг хангасан гишүүнээр элсэхийг хүсэгч нь хоршооны даргаас элсэгчийн материал (өргөдлийн загвар, гишүүний анкетийн маягт)-ыг авна. Өргөдөлдөө гишүүн болохыг хүсэх болсон шалтгааныг дурдаж, хоршооны ямар баримт бичгүүдтэй танилцсан, тэдгээрийг хүлээн зөвшөөрч, биелүүлж ажиллахаа батламжлан илэрхийлсэн хэлбэртэй байна. Тэрээр урьдчилан танилцаж амжаагүй бол энэ явцдаа хоршооны дүрэм, журамтай нарийвчлан танилцана. Танилцуулах үйл ажиллагааг хоршооны тэргүүлэгчид зохион байгуулж өгөх үүрэгтэй.

Хоршооны гишүүнээр элсэхийг хүсэгч нь гишүүний бичгээр гаргасан өргөдөл болон гишүүний анкетийг үнэн зөв бэлтгэн элсэлтийн татвар, хувь нийлүүлэх хөрөнгөө нийлүүлснийг баталгаажуулсан баримт (хөрөнгийг хөдөлмөр оролцоогоор бүрдүүлэх тохиолдолд зайлшгүй биш), иргэний үнэмлэхийн хуулбар зэрэг материалын хамт хоршооны даргад өргөн барина. Хоршооны дарга нь баримт материалыг хүлээн он, сар, өдрийг тэмдэглэн хүлээн авна.

Элсэлтийн татвар, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, тэдгээрийг төлөх хэлбэрийг хоршооны дүрэмд заасныг баримтлан гүйцэтгэсэн байна. Иж бүрдэл болоогүй баримт, материалыг хүлээн авахгүй ба хүлээн аваагүй шалтгааныг өргөдөл гаргагчид тайлбарлаж өгнө.

Гишүүнчлэлийн өргөдөл, материалыг ямарч хугацаанд гаргаж болох ба түүнийг хүлээн авсан хоршооны дарга нь нэг сарын дотор гишүүнчлэлийн асуудлыг хоршооны тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэр гаргуулна.

Шийдвэрийг гаргахдаа тэргүүлэгчид нь өргөдөл, материалыг судлан элсэхийг хүсэгч нь хоршооны дүрэм, журам, бүтээгдэхүүн нийлүүлэх зарчимтай танилцаж хүлээн зөвшөөрсөн болон түүнийг биелүүлэх чадварын байдал зэргийг хамтран хэлэлцэж, илээр санал хурааж,

олонхийн саналаар шийдвэрлэнэ. Шийдвэр нь хурлын протокол (хурлын тогтоол)-ын хэлбэртэй байна.

Хурлын шийдвэрийг 14 хоногийн дотор гишүүнд элсэхээр хүсэгчид танилцуулж, бүртгэлийг хийж, “Гишүүний дэвтэр” буюу батламжийг шинээр элсэгч гишүүнд гардуулан өгнө.

Гишүүн нь хоршоонд хуулийн этгээдийн бүртгэлд нэмэлт өөрчлөлт оруулахад шаардлагатай анкет, 2 хувь зураг, иргэний үнэмлэхийн хуулбар зэрэг материалыг нэмж бүрдүүлэн өгнө. Энэхүү нэмж бүрдүүлсэн материал нь улсын бүртгэлийн байгууллагад хүргэгдэх ба анхдагч материал нь хоршоонд хадгалагдаж үлдэнэ. Ажил хөнгөвчлөх үүднээс улсын бүртгэлийн ажиллагаанд ашиглах баримт, материалыг эхний шатанд хамтатган бүрдүүлж болно. Гишүүнчлэлд орсон нэмэлт өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлэх ажлыг хоршооны тэргүүлэгчид хариуцна.

Хоршооны гишүүдийн бүртгэлийг хоршооны дарга нэгбүрчлэн хөтөлж, баяжуулж байх үүрэгтэй. Энэхүү журмыг батлагдсан өдрөөс дагаж мөрдөнө.